МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Д.ҮҮРИЙНТУЯА ТАНАА

МОНГОЛ УЛС
ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРОО
Нэгдсэн үндэстний гудамж 20, 6-р хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200
Утас: (976) 70071113, 70071117
Цахим шуудан: secretariat@ncge.gov.mn,
Цахим хуудас: www.ncge.gov.mn

2026.11.13 №256

танай _____-ны №_____-т

Хуулийн төсөлд санал хүргүүлэх тухай

Танаас ирүүлсэн 2026 ны 11 дүгээр сарын 03-ны өдрийн УИХ-03/12336 дугаар бүхий “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төсөлтэй танилцлаа. Тус хуулийн төслийг Жендэрийн үндэсний хорооны ажлын алба нь бүрэн дэмжиж байгаагаа илэрхийлж байна.

Энэхүү хуулийн өөрчлөлт нь Монгол Улсын Үндсэн хууль болон Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (ЖЭТБХТХ)-д заасан эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш эрхийн зарчим болон тусгай арга хэмжээг бодитоор хэрэгжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн шийдвэр гаргах түвшин дэх бодит оролцоог нэмэгдүүлэх, улс төрийн намаас нэр дэвшигчдэд үзүүлэх санхүүгийн дэмжлэгийн тэгш байдлыг хангах, түүнчлэн НҮБ-ын Эмэгтэйчүүдийг алагчилах үзлийг устгах Хорооноос ирүүлсэн зөвлөмж, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтэд ахиц гаргах эрх зүйн зохицуулалт болоход чухал ач холбогдолтой байна.

Цаашид тус хуулийн төсөлд тусгуулахаар хүргүүлж буй 29, 32 дугаар зүйлүүдэд тусгуулах нэмэлт зохицуулалтыг зайлшгүй тусгах хэрэгцээ, шаардлага байгааг онцгойлон дурдаж, холбогдох саналаа хүргүүлж байна.

Хавсралт ... хуудастай

Хүндэтгэсэн,

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
БӨГӨӨД АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА А.АДИЛБИШ

УЛААНБААТАР ХОТ
ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРОО
9024041461 9917381 СТ323

АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ТУСГУУЛАХ САНАЛ

Жөндэрийн үндэсний хорооны Ажлын алба *2026.11.11-ний өдөр*

№	Шинэчилсэн найруулгын төсөл	Тусгуулах санал /Хуульд нэмэлт өөрчлөлт оруулах саналын томъёолол/	Эрх зүйн үндэслэл Хэрэгцээ, шаардлага
	29 дүгээр зүйл.Нам, эвслээс нэр дэвшүүлэх		
1.		**29.2.** Нам, эвслээс тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшиж байгаа нийт нэр дэвшигчийн ***40-өөс доошгүй хувь*** нь аль нэг хүйсийн нэр дэвшигч байна."	УИХ-ын сонгуулийн тухай хууль болон НҮБ-ын Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах хорооны 2022 оны дүгнэлт, зөвлөмжид тусгасан жендэрийн квотын хэрэгжилтэд хяналт тавих механизмыг бүрдүүлж, хэрэгжилтийг хангахын зэрэгцээ Олон Улсын Парламентын Холбоо (ОУПХ)-ны аргачлалаар хийсэн Парламентын хүний эрх, жендэрийн мэдрэмжтэй байдлын өөрийн үнэлгээнээс гарсан зөвлөмжийг үе шаттай хэрэгжүүлэх.
2.	**Нэмэлт хэсэг**	**29.4.** Нам, эвслээс орон нутгийн Хурлын сонгуульд нэр дэвшүүлэхдээ нэр дэвшигчийн жагсаалтад эрэгтэй, эмэгтэй хүйсээр сөөлжлүүлсэн дарааллаар бүртгэнэ.	Цаашид тус хуулийн 32 дугаар зүйлд "Нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзах" нам, эвслээс нэр дэвшүүлсэн нийт нэр дэвшигчийн бүрэлдэхүүн нь тус хуулийн төслийн 29.2-т заасан хүйсийн төлөөллийн доод хязгаарыг хангаагүй тохиолдолд тухайн "нам, эвслээс нэр дэвшигчдийг бүртгэхээс татгалзах" зохицуулалтыг тусгах нь чухал байна. Ингэснээр хүйсийн төлөөллийн доод хязгаарыг хангах хуулийн шаардлагын хэрэгжилтийг бодитой хангах, квотыг мөрдүүлэх эрх зүйн хариуцлагын механизмыг бүрдүүлэх нөхцөл бий болно.
3.	**Нэмэлт хэсэг**	**29.5.** Нам, эвсэл нь шийдвэр гаргах түвшинд жендэрийн эрх тэгш байдлыг хангах, хөгжлийн бэрхшээлтэй иргэний улс төрийн оролцоог дэмжих бодлогыг мөрийн хөтөлбөр болон нэр дэвшүүлэх	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 8 дугаар зүйл буюу Улс төрийн хүрээн дэх жендэрийн эрх тэгш байдлын баталгааг хангах шаардлагуудтай уялдуулан боловсруулсан.

		дотоод журамдаа тусган нэр дэвших боломжоор хангана.	
4.	**Нэмэлт хэсэг**	**29.6.** Нам, эвсэл нь гурав ба түүнээс дээш мандаттай сонгуулийн тойрогт нэр дэвшүүлэхдээ тухайн тойрогт нэр дэвшигчдийн 40-өөс доошгүй хувь нь аль нэг хүйсийн нэр дэвшигч байх зарчмыг баримтална. Энэхүү хувь хэмжээг тооцоход бутархай тоо гарвал аравны орныг бүхэл болгон тоймлоно.	Хүйсийн төлөөллийн доод хязгаарыг тооцоход бутархай тоо гарсан тохиолдолд хэрхэн тоймлохыг хуульд тодорхой, шууд тусгаж өгөх шаардлагатай. Ингэснээр сонгуулийн хороод болон улс төрийн намуудын зүгээс квотын тооцоолол, нэр дэвшигчийн бүртгэлтэй холбоотой харилцан адилгүй тайлбар, маргаан үүсэхээс урьдчилан сэргийлж, хуулийн хэрэгжилтийг нэг мөр хангах эрх зүйн тодорхой байдлыг бүрдүүлнэ.
5.	**Нэмэлт хэсэг**	**29.7.**Хоёр мандаттай сонгуулийн тойрогт нам, эвсэл нь хоёр нэр дэвшигч дэвшүүлэх тохиолдолд эрэгтэй, эмэгтэй хүйсийн төлөөллийг тэгш хангаж нэр дэвшүүлнэ.	Нийслэл, аймгийн төв зэрэг олон мандаттай томоохон тойрогт нэр дэвшигчдийн бүрэлдэхүүн аль нэг хүйсийн төлөөлөл орхигдохоос урьдчилан сэргийлж, хүйсийн тэнцвэртэй төлөөллийг хангах боломж бүрдэнэ.
		32 дугаар зүйл.Нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзах	
6.	**Нэмэлт хэсэг**	**32.1.10.**нам, эвслээс нэр дэвшүүлэхдээ энэ хуулийн төслийн 29.2, 29.4, 29.5-д заасан хүйсийн тэгш байдлыг хангах шаардлагыг хангаагүй;	Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн 32.1-д нэр дэвшигчдийн хүйсийн төлөөллийн доод хязгаар буюу квотын шаардлагыг зөрчсөн тохиолдолд бүртгэхээс татгалзах үндэслэл тодорхой тусгагдаагүй байгааг нөхөн зохицуулж, 32.1.10 дахь заалтыг шинээр нэмснээр уг шаардлагыг хуульд нийцүүлэн хангаагүй нам, эвслийн нэр дэвшигчдийг бүртгэхээс татгалзах эрх зүйн үндэслэлийг тодорхой болгоно. энэ санаачилж байгаа хуулинд 40 хувийн квотоо хангаагүй тохиолдолд СЕХ бүртгэж авахгүй байх хариуцлагын механизмыг хамтад нь суулгаж өгч байж, энэ түр тусгай арга хэмжээ хэрэгжих нөхцөл бүрдэнэ.
7.	**Нэмэлт хэсэг**	**Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт "32.1.10.энэ хуулийн 29.2-т заасан нэр дэвшүүлэх ажиллагааны**	1. УИХ-ын 2023 оны 6 сард УИХ-ын Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдлыг хангах, улс төрийн төлөөлөл багатай хүйсийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор хуулийн 30.2 дахь хэсэгт нэр дэвшигчдийн хүйсийн төлөөллийн доод

		журам зөрчсөн бол нийт нэр дэвшигчийг." гэсэн агуулга бүхий 32.1.10 дахь заалтыг нэмэх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгуулах	хязгаарыг үе шаттай нэмэгдүүлэх зохицуулалт тусгасан. Тодруулбал, 2024 оны ээлжит сонгуулиар нам, эвслээс нэр дэвшүүлсэн нийт нэр дэвшигчийн 30-аас доошгүй хувь, 2028 оны ээлжит сонгуулиар 40-өөс доошгүй хувь нь аль нэг хүйсийн төлөөлөл байхаар хуульчилсан. Түүнчлэн хуулийн 33.1.10 дахь заалтаар 30.1, 30.2, 30.4, 30.6-д заасан нэр дэвшүүлэх ажиллагааны журмыг зөрчсөн тохиолдолд тухайн нам, эвслээс нэр дэвшүүлсэн нийт нэр дэвшигчийн бүртгэхээс татгалзах, харин 29.7-д заасныг зөрчсөн бол тухайн нэр дэвшигчийг сонгуулийн хороо бүртгэхээс татгалзахыг үүрэг болгосон. Тиймээс УИХ-ын 2024 оны ээлжит сонгуульд 21 нам эвслүүд хуулийн энэ заавал хэрэгжүүлэх шаардлагыг хангаснаар нийт 1341 нэр дэвшигчийн 520 нь эмэгтэй нэр дэвшигч байж, 126 гишүүн сонгогдсны 25.4 хувь буюу 32 эмэгтэй болсон. 2.УИХ дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл 25.4 хувь болсноор Азийн дунджаас 4 пунктээр илүү, ОУ-ын дундажтай дөхөж очсон юм. 2024 онд Азид хамгийн өндөр өсөлтийг авчирсан гэж зарлагдсан. ОУПХ-ны улс орнуудын зэрэглэлээр 40 улс, ДЭЗФ-ын жендэрийн зөрүүтэй байдлын индексээр 20 байр урагшилсан. 3.Монгол Улсын Үндсэн хууль, ОУ-ын гэрээ конвенцуудтэй нийцнэ. /энэ талаар хууль санаачлагч хангалттай бичсэн байна/. 4.НҮБ- ын Эмэгтэйчүүдийн байгууллагын 2025 оны жагсаалтад Монгол орон нутгийн төлөөллийн байгууллагад эмэгтэйчүүдийн эзлэх хувиар (27.6%) 142 улсаас 77-д жагсаж байгаа. Хэрэв энэ хууль 40 хувийн хүйсийн квотыг заавал биелүүлэхээр нэмэж тусгавал Аймаг, Нийслэл, сум, дүүргийн ИТХ-д сонгогдох эмэгтэй төлөөлөгчдийн хувь 35-д хүрч одоогийн жагсаалтаар 41–42-т эрэмбэлэгдэж,

			дэлхийн дундажтай (35.6%) бараг тэнцэнэ, мөн 37 байраар урагшилна.
8.	**Нэмэлт хэсэг**	**32.1.11.энэ хуулийн төслийн** олон мандаттай тойрогт нам, эвслээс нэр дэвшүүлэхдээ энэ хуулийн 29.6, 29.7-д заасан тойрог тус бүр дэх хүйсийн квотыг хангаагүй.	Хуулийн төслийн 29.5, 29.6 дахь хэсэгт шинээр зохицуулалт нэмж тусгаж байгаатай холбогдуулан тэдгээрт заасан шаардлагын хэрэгжилтийг хангах, зөрчсөн тохиолдолд нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзах эрх зүйн үндэслэлийг бүрдүүлэх зорилгоор холбогдох заалтыг шинээр нэмж тусгаж байна.
	33 дугаар зүйл.Нөхөн нэр дэвшүүлэх		
9.	**Нэмэлт хэсэг**	**33.3.** Энэ хуулийн заасан үндэслэлээр нам, эвслээс нэр дэвшигчийг нөхөн нэр дэвшүүлэх тохиолдолд хуульд заасан хугацаанд өмнөх нэр дэвшигчтэй ижил хүйсийн хүнийг нөхөн нэр дэвшүүлнэ.	Тус хуулийн 33.1-д заасан үндэслэлээр (бүртгэхээс татгалзсан, нас барсан, шүүхээр ял шийтгүүлсэн) өөр хүнийг нөхөн нэр дэвшүүлэхэд өмнөх эмэгтэй (эсвэл эрэгтэй) нэр дэвшигчийн оронд эсрэг хүйсийн хүнийг нэр дэвшүүлж, улмаар тухайн нам, эвслийн нийт нэр дэвшигчийн 40 хувийн квот алдагдах эрх зүйн хийдэл үүсэж байна. НҮБ-ын CEDAW-ийн хорооноос 2022 онд Монгол Улсад өгсөн дүгнэлт, зөвлөмжид *"жендэрийн квотын хэрэгжилтэд хяналт тавих, квотыг зөрчих болон түүнээс зайлсхийх үйлдэлд үр нөлөөтэй арга хэмжээ авах"* тухай тусгайлан зөвлөсөн. Ижил хүйсийн хүнийг нөхөн нэр дэвшүүлэх үүрэг нь энэхүү олон улсын зөвлөмжийг бодитоор хэрэгжүүлэх чухал хяналтын механизм болно.
	51 дүгээр зүйл.Сонгуулийн зардлын данснаас зарлага гаргах		
10.	**Нэмэлт хэсэг**	51.3. Нам, эвслийн сонгуулийн зардлын данснаас нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дансанд санхүүгийн дэмжлэг шилжүүлэхдээ хүйсээр ялгаварлахгүйгээр нэг нэр дэвшигчид ногдох дүнг ижил хэмжээгээр тооцож шилжүүлнэ.	ЖЭТБХтХ-ийн 8.2.Бүх шатны сонгуульд нэр дэвшигч эрэгтэй, эмэгтэй хүний сонгуулийн сурталчилгаанд зориулан улс төрийн намаас үзүүлэх санхүүгийн дэмжлэг ижил хэмжээтэй байна гэж заасны дагуу уялдуулан шинээр найруулсан.
	55 дугаар зүйл.Хандив өгөх, хүлээн авахыг хориглох		
11.	55.5.Нам өөрийн өмчлөлийн үл хөдлөх болон хөдлөх эд		ЖЭТБХтХ-ийн 8.2.Бүх шатны сонгуульд нэр дэвшигч эрэгтэй, эмэгтэй хүний сонгуулийн

	хөрөнгийг нам, эвслийн болон нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгаанд ашиглуулахдаа нэр дэвшигчдэд **хүйсээр ялгаварлахгүйгээр тэгш, хүртээмжтэй хуваарилах бөгөөд энэ нь хандивт тооцогдохгүй.**		сурталчилгаанд зориулан улс төрийн намаас үзүүлэх санхүүгийн дэмжлэг ижил хэмжээтэй байна гэж заасны дагуу уялдуулан шинэчлэх шаардлагатай.
12.	55.6. Нэр дэвшигч болон нам, эвслийн сонгуулийн зардлын данс хооронд шилжүүлсэн мөнгөн хөрөнгийг хандивт тооцохгүй **бөгөөд нам, эвслээс нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгаанд зориулан үзүүлэх санхүүгийн дэмжлэг нь эрэгтэй, эмэгтэй нэр дэвшигчид ижил хэмжээтэй байна.**		
	56 дугаар зүйл.Сонгуулийн зардлын тайлан		
13.	**Нэмэлт хэсэг**	56.4.6. нам, эвслээс эрэгтэй, эмэгтэй нэр дэвшигч тус бүрд олгосон санхүүгийн дэмжлэгийн хэмжээ, гүйлгээний мэдээлэл.	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 8.4 дэх хэсэгт улс төрийн нам 8.2 дахь хэсгийн хэрэгжилтийн тайланг жил бүр Жендэрийн үндэсний хороонд хүргүүлэх үүрэгтэй байдаг. Төрийн аудитын байгууллагад өгдөг сонгуулийн зардлын тайланд (56.4) дээрх мэдээллийг тусгаснаар аудитын дүгнэлтээр баталгаажсан бодит тоо мэдээлэл бий болж, Жендэрийн үндэсний хороо хяналт тавих бүрэн боломжтой болно.